



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2026/ 050/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Хишгээ Утас:99964238 Цахим хаяг: nishge.da@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
3.1 Төлбөрийн акт .....	9
3.2 Зөвлөмж .....	10
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>26</b>
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/.....	26
<b>5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....</b>	<b>26</b>

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 194  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.БАДАМХОРЛОО ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

2025 онд Боловсролын үнэлгээний төвийн үнэлгээгээр 94.5 хувийн гүйцэтгэлтэй, 3 дугаар түвшинд үнэлэгдэж, STEAM хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ховд аймгийн Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийг 2025 онд хоёр удаа тодотгол хийж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 220,4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, оны эцэст 60.8 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулахгүйгээр төсөвт төвлөрүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 81 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 97.0 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,616,449.1</b>	<b>103,346,780.6</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	110,465,497.3	60,782,903.8
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	110,465,497.3	60,782,903.8
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	110,465,497.3	60,782,903.8
31211	Төрийн сангийн харилцах	110,465,497.3	60,782,903.8
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	199.8	1,000,199.8
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,000,000.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	199.8	199.8
3351	Байгууллагаас авах авлага	199.8	199.8
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,150,752.0	41,563,677.0
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,220,000.0	1,220,000.0
35130	Эм боох материал	1,220,000.0	1,220,000.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	182,000.0	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	37,748,752.0	40,343,677.0
35420	Аж ахуйн материал	27,907,790.0	27,922,790.0
35440	Түлш, шатах тослох материал	30,000.0	30,000.0
35460	Хүнсний материал	5,117,585.0	7,697,510.0
35470	Бусад хангамжийн материал	4,693,377.0	4,693,377.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>696,061,961.9</b>	<b>708,857,558.50</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	696,061,961.9	708,857,558.50
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	680,621,361.9	693,416,958.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	727,285,912.4	727,285,912.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(143,790,319.0)	(167,188,808.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,738,073.0	106,922,479.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,156,548.6)	(51,928,359.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,394,081.0	105,346,025.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,849,836.8)	(29,020,289.61)
39217	Ном	2,000,000.0	2,000,000.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,440,600.0	15,440,600.0
39301	Програм хангамж	649,500.0	649,500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(649,500.0)	(649,500.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,440,600.0	15,440,600.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>845,678,411.1</b>	<b>812,204,339.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,188,610.0</b>	<b>1,555,692.9</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,188,610.0	1,555,692.9
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,188,610.0	1,555,692.9
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	294,567.9
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,160,610.0	1,160,625.0
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	28,000.0	100,500.0
41361	Байгууллагад төлөх өглөг	28,000.0	100,500.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>844,489,801.1</b>	<b>810,648,646.24</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	844,489,801.1	810,648,646.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	623,175,477.0	623,175,477.0
51101	Өмч: - төрийн	623,175,477.0	623,175,477.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(72,433,218.9)	(106,274,373.74)
51210	Өмнөх үеийн үр дүн	(72,433,218.9)	(72,433,218.9)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(33,841,154.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,747,543.0	293,747,543.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>845,678,411.1</b>	<b>812,204,339.09</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>889,852,950.0</b>	<b>923,418,650.5</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>94,870,450.0</b>	<b>54,398,650.5</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	94,870,450.0	54,398,650.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,870,450.0	54,398,650.5
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	94,870,450.0	54,398,650.5
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>794,982,500.0</b>	<b>869,020,000.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	755,951,000.0	822,387,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	755,951,000.0	822,387,800.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,031,500.0	46,632,200.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,031,500.0	46,632,200.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>780,589,644.4</b>	<b>946,512,929.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>780,589,644.4</b>	<b>946,512,929.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	760,045,471.8	940,871,528.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	542,585,696.8	700,779,486.2
210101	Үндсэн цалин	338,101,232.1	412,233,890.8
210102	Нэмэгдэл	172,060,204.7	227,002,895.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,710,000.0
210104	Урамшуулал	32,424,260.0	39,832,700.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,058,142.9	86,788,395.1
210201	Тэтгэврийн даатгал	46,304,386.1	60,789,236.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,364,525.6	6,984,554.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,682,263.0	3,450,037.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,191,170.6	2,951,094.1
210205	Эрүүл мэндийн даатгал	9,515,797.6	12,613,472.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,302,027.4	43,826,408.5
210301	Гэрэл, цахилгаан	7,297,339.9	8,334,258.5
210302	Түлш, халаалт	25,004,687.5	35,042,150.0
210303	Цэвэр, бохир ус		450,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	43,881,960.0	51,363,450.0
210502	Хоол, хүнс	43,881,960.0	51,363,450.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,250,000.0	1,808,980.0
210604	Урсгал засвар	1,250,000.0	1,808,980.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,215,250.0	1,167,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,655,250.0	182,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	560,000.0	985,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	66,752,394.7	55,137,808.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,893,610.0	16,084,930.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,581,900.0	6,459,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,276,884.7	43,340,753.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,544,172.6	5,641,401.5
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,954,700.0	5,035,590.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,954,700.0	5,035,590.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,589,472.6	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,589,472.6	-

**Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	605,811.5
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		605,811.5
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>109,263,305.6</b>	<b>(33,841,154.81)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>109,263,305.6</b>	<b>(33,841,154.81)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	812,030,100.0	869,020,000.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	794,982,500.0	869,020,000.0
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	755,951,000.0	822,387,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	755,951,000.0	822,387,800.0
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	737,278,719.1	918,702,593.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	737,278,719.1	918,702,593.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	716,734,546.5	912,501,682.0
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	546,092,179.9	704,635,703.5
210101	Үндсэн цалин	336,289,169.1	420,811,023.9
210102	Нэмэгдэл	177,378,750.8	225,873,376.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,708,311.1
210104	Урамшуулал	32,424,260.0	36,242,991.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,623,029.2	83,078,100.0
210201	Тэтгэврийн даатгал	40,996,929.2	53,583,100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,656,600.0	9,562,300.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,828,300.0	3,324,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,828,300.0	3,324,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,312,900.0	13,283,300.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,192,027.4	43,826,408.5
210301	Гэрэл, цахилгаан	7,297,339.9	8,334,258.5
210302	Түлш, халаалт	23,894,687.5	35,042,150.0
210303	Цэвэр, бохир ус		450,000.0
2105	<b>Нормативт зардал</b>	36,909,550.0	53,943,360.0
210502	Хоол, хүнс	36,909,550.0	53,943,360.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,250,000.0	2,199,980.0
210604	Урсгал засвар	1,250,000.0	2,199,980.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,747,375.0	985,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,837,250.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,910,125.0	985,000.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,920,385.0	23,833,130.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,338,485.0	18,526,630.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,581,900.0	5,306,500.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,544,172.6	6,200,911.5
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,954,700.0	5,595,100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,954,700.0	5,595,100.0
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	605,811.5
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		605,811.5
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	74,751,380.9	(49,682,593.5)
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	74,751,380.9	(49,682,593.5)
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		110,465,497.3
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	110,465,497.3	60,782,903.8

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(72,433,218.9)	844,489,801.1
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(72,433,218.9)	844,489,801.1
C07	Тайлант үеийн үр дүн			(22,488,467.6)	22,488,467.6)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(72,433,218.9)	844,489,801.1
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(72,433,218.9)	844,489,801.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(72,433,218.9)	844,489,801.1
D08	Тайлант үеийн үр дүн			(33,841,154.81)	(33,841,154.81)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(106,274,373.74)	810,648,646.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>970,732,500.0</b>	<b>918,096,782.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	970,732,500.0	918,096,782.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	965,137,400.0	912,501,682.0
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>731,645,100.0</b>	<b>704,635,703.5</b>
Үндсэн цалин	450,117,100.0	420,811,023.9
Нэмэгдэл	251,157,900.0	225,873,376.9
Унаа хоолны хөнгөлөлт		21,708,311.1
Урамшуулал	30,370,100.0	36,242,991.7
Гэрээт ажлын хөлс		
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>90,909,400.0</b>	<b>83,078,100.0</b>
Тэтгэврийн даатгал	61,643,600.0	53,583,100.0
Тэтгэмжийн даатгал	7,316,500.0	9,562,300.0
ҮОМШӨ-ний даатгал	3,658,200.0	3,324,700.0
Ажилгүйдлийн даатгал	3,658,200.0	3,324,700.0
Эрүүл мэндийн даатгал	14,632,900.0	13,283,300.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,202,100.0</b>	<b>43,826,408.5</b>
Гэрэл, цахилгаан	9,360,000.0	8,334,258.5
Түлш, халаалт	37,242,100.0	35,042,150.0
Цэвэр, бохир ус	600,000.0	450,000.0
Урсгал засвар	2,200,000.0	2,199,980.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,104,800.0</b>	<b>985,000.0</b>
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,104,800.0	985,000.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>28,678,000.0</b>	<b>23,833,130.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	23,365,400.0	18,526,630.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,312,600.0	5,306,500.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,595,100.0</b>	<b>5,595,100.0</b>
Бусад урсгал шилжүүлэг	5,595,100.0	5,595,100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,595,100.0	5,595,100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>970,732,500.0</b>	<b>868,414,200.0</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	834,021,000.0	822,387,800.0
Улсын төсвөөс санхүүжих	834,021,000.0	822,387,800.0
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	47,202,100.0	46,026,400.0
Орон нутгийн төсвөөс	47,202,100.0	46,026,400.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	89,509,400.0	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	89,509,400.0	

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		110,465,497.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		60,782,903.8

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 103,275.42 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 99,368.0 мянган төгрөгийн бүртгэл, тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэл зөрүүтэй илэрхийлсэн 99,368.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн

Аудитаар залруулагдаагүй 3,907.4 мянган төгрөгийн зөрчилд<sup>2</sup> 3,907.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

**5.1.1 Илрүүлэлт:** 2025 оны жилийн эцсээр цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг нэгтгэн тооцоогүйгээс нэр бүхий 13 хүнтэй холбоотой 1,941.3 мянган төгрөгийн татварыг дутуу хөнгөлсөн, мөн нэр бүхий 8 иргэнтэй холбоотой 100.0 мянган төгрөгийн татварыг илүү суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт / 0-6,0 сая төгрөгийн орлогод 0,24 сая төгрөг /дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөвлөмж өглөө.

**3.1.2 Илрүүлэлт:** Аудитаар байгууллагын удирдлага нь нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2026 оны 6 сарын 20-ны өдрийн А/20 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэл 2 сар 25 хувиар 779.5/долоон зуун далан есөн мянга таван зуун/ урамшуулалтай давхардуулан цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 8 дүгээр сарын 22 өдрийн А/24 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1,559,000 (Нэг сая таван зуун тавин есөн) төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, 2025 оны 7, 8 сард нягтлан бодогчид ур чадварын нэмэгдлийг илүү олгоод авлагаар бүртгээгүй, нийт 1,866.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.*

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт:** Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 2467 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэгдэж 7,401.0 төгрөгийн зардлыг гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бичиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй. , санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** *Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс: Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан	1.0	99,368.0	1.0	99,368.00	1.0	99,368.00
<b>Нийт алдааны дүн</b>	<b>1.0</b>	<b>99,368.0</b>	<b>1.0</b>	<b>99,368.0</b>	<b>1.0</b>	<b>99,368.0</b>

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:			
	Тоо	Дүн	Зөвлөмж		Төлбөрийн акт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогчид балансын урамшуулал олгосон. 7-8 сард ажил хавсран гүйцэтгэж байгаа байгууллагатай давхардуулан ур чадварын нэмэгдэл авсан.	1	1,866.1			1	1,866.1
ХХОАТ-ыг нэгтгэн тооцоогүй илүү дутуу тооцсон	1	2,041.3			1	2,041.3
Боловсрол мэдээллийн esis.edu.mn систем дэх ирцийн бүртгэл багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журнал дахь хүүхдийн тоо 2576 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн	1			1		
<b>Нийт зөрчлийн дүн</b>	<b>3</b>	<b>3,907.4</b>		<b>1</b>	<b>0</b>	<b>3,907.4</b>

#### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			